



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН  
АЛБА  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 29/02/04/05

Арвайхээр сум

Зөрчил арилгуулах тухай

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын 2024 оны 04 дүгээр сарын 12 -ны өдөр баталсан 29/04 тоот удирдамжийн дагуу Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2022, 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Н.Лхамдолгор, аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ч.Буянбат, Д.Чулуунбадрах нар 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Шалгалтаар Хоршоо хөгжүүлэх сангаас 2020 онд зээл авсан иргэн Х.Энхтайваны 3,509,699 (гурван сая таван зуун есөн мянга зургаан зуун ерэн ес) төгрөгийн зээл, хүү, алдангийн төлбөр 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 6.9 -т "Хуулийн этгээд иргэн нь авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө.", 3.4.11-т "Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтууд,

Хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээний 6.2.2-т "Гэрээний 2.2-т зээлийн үндсэн төлбөрийг хавсралт №1-д тусгасан хуваарийн дагуу төлж дуусгана", 2.3-т "зээлдэгч зээлийн үндсэн хүүг 0,25 хувиар тооцож, улирал, сар бүрийн эхний 7 хоногийн ажлын өдөрт багтаан сангийн 100102055401 тоот дансанд төлөх" гэсэн заалт, "Төрийн хяналт шалгалтын тухай хууль"-ийн 10.12.2-т "Аж ахуйн нэгж, байгууллага иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн тул "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д заасан "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд шаардлага тавьж

622000002

хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах” гэсэн улсын /ахлах/ байцаагчийн бүрэн эрхийнхээ хүрээнд ШААРДАХ НЬ:

1. Сум хөгжүүлэх сангаас зээл авч, зээлээ эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй Х.Энхтайвангийн хугацаа хэтэрсэн 3,509,699 (гурван сая таван зуун есөн мянга зургаан зуун ерэн ес) төгрөгийн зээл, хүү, алдангийн хамт төлүүлэх.

Энэхүү албан шаардлагын биелэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны дотор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан тоотоор ирүүлэхийг Баян-Өндөр сумын Засаг дарга С.Чулууншагай, Санхүүгийн албаны дарга Ю.Дуламхорлоо нарт хариуцуулав.

Албан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 16.1.2-т заасны дагуу хариуцлага тооцох болно.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:


  
 САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
 УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Н.ЛХАМДОЛГОР  
 САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
 УЛСЫН БАЙЦААГЧ Ч.БУЯНБАТ  
 САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
 УЛСЫН БАЙЦААГЧ  Д.ЧУЛУУНБАДРАХ

ХҮЛЭЭН АВСАН:


  
 БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГА  С.ЧУЛУУНШАГАЙ  
 САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА  Ю.ДУЛАМХОРЛОО  
 ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ХОРШООНЫ  
 АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  Ц.ПҮРЭВДУЛАМ